

ЭРЭЛ ХАЙГУУЛЫН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ ХУДАЛДАН АВАХ БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Энэхүү Гэрээг Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан АСА Групп хязгаарлагдмал хариуцлагатай компани (Регистрийн дугаар 2804255, Улсын бүртгэлийн дугаар 9011039072) (цаашид “Худалдагч” гэх); болон

Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан Новаметал ресурс хязгаарлагдмал хариуцлагатай компани (Регистрийн дугаар 5372658, Улсын бүртгэлийн дугаар 9011232015) (цаашид “Худалдан авагч” гэх) нарын хооронд 2010 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр байгуулав.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- А. Худалдагч нь Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль (цаашид “Ашигт малтмалын тухай хууль” гэх)-ийн дагуу Монгол улсын Ашигт малтмалын газрын Геологи, Уул Уурхайн Кадастрын Хэлтэс (цаашид “ГУУКХ” гэх)-ээс олгосон ашигт малтмалын хайгуулын 8573X тоот тусгай зөвшөөрөл (цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх)-ийн бүртгэгдсэн эзэмшигч мөн. Тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан хамгийн сүүлийн үеийн өргөрөг, уртраг дахь солбицлын цэгүүдийн хоорондох талбайг энэхүү Гэрээнд Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбай гэнэ.
- Б. Худалдагч нь Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайд эрэл, хайгуулын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд холбогдох тайланг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Засгийн газрын холбогдох агентлагуудад өгсөн. Тэрхүү тайлан болон эрэл, хайгуулын ажилтай холбоотой бусад баримт, мэдээллийг энэхүү Гэрээнд Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээлэл гэнэ.
- В. Худалдагч нь Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээллийг энэхүү Гэрээний нөхцөл, болзлуудын дагуу худалдах, Худалдан авагч нь худалдан авах хүсэлтэй байгаа бөгөөд тийнхүү худалдаж, худалдан авсны дараа Худалдагч нь Тусгай зөвшөөрлийг Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 49.2 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх хүсэлтэй байна.

ТОХИРОЛЦОО

ИЙНХҮҮ талууд дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

- 1. Худалдагч нь Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээллийг энэхүү Гэрээний нөхцөл, болзлуудын дагуу Худалдан авагчид худалдах, Худалдан авагч нь уг мэдээллийг Худалдагчаас худалдан авахаар үүгээр тохиролцов.

2. Тусгай зөвшөөрлийн Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээллийг худалдан авах үнэ (цаашид “Худалдан авах үнэ” гэх) нь 500,000 (Таван зуун мянган) төгрөг байна.
3. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурах өдөр Худалдагч дараах баримт бичгүүдийг Худалдан авагчид хүлээлгэн өгнө.
 - а) Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хавсралтууд болон зургийн хамт (цаашид “Тусгай зөвшөөрлийн баримт бичгүүд” гэх);
 - б) Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх гэрээний гарын үсэг зурж баталгаажуулсан эх хувь болон Тусгай зөвшөөрлийг Худалдан авагчид шилжүүлэхэд шаардагдах холбогдох баримт бичгүүд (хамтад нь цаашид “Худалдагчийн Тусгай зөвшөөрөл шилжүүлэх баримт бичгүүд” гэх);
 - в) Худалдагчийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар; мөн
 - г) Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээлэл.
4. Худалдагч нь Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээлэл худалдсантай холбогдуулан Худалдагчийн төлөх татварыг холбогдох татварын албанд төлж, Татвар төлсөн баримтыг хүлээн авахаа зөвшөөрч байна.
5. Худалдагч нь а) Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээллийн цорын ганц хууль ёсны өмчлөгч бөгөөд б) Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээллийг 3-т заасны дагуу Худалдан авагчид шилжүүлснээр Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайн мэдээллийг өмчлөх Худалдагчийн эрх, хууль ёсоор эзэмших эрх болон уг мэдээлэл дэх Худалдагчийн ашиг сонирхлыг аливаа барьцааны эрх болон гуравдагч этгээдийн эрхээс чөлөөтэйгээр Худалдан авагчид худалдаж, шилжүүлсэнд тооцно гэдгийг Худалдан авагчид үүгээр мэдэгдэн баталж байна.
6. Худалдан авагч нь Тусгай зөвшөөрлийн баримт бичгүүд болон Худалдагчийн Тусгай зөвшөөрөл шилжүүлэх баримт бичгүүдийг ГУУКХ-т аль болох түргэн хүлээлгэн өгнө. Үүнтэй холбогдуулан Худалдагч нь Тусгай зөвшөөрлийг Худалдан авагчид шилжүүлэх ажиллагааг бүрэн гүйцэтгэхэд шаардагдах бүх зүйлийг хийж, бүх хэлцэл, баримт, шилжүүлэг болон шаардлагатай бусад бүх баримт бичгүүдийг гүйцэтгэхээ зөвшөөрч байна.
7. Худалдагч нь дараах мэдэгдэл, баталгааг үүгээр гаргаж байна:
 - 7.1 Тусгай зөвшөөрөл нь Гуравдагч этгээдийн эрхээс чөлөөтэй;

- 7.2 Худалдагч нь Тусгай зөвшөөрөлтэй холбогдуулан өөр этгээдтэй гэрээ байгуулаагүй;
- 7.3 Тусгай зөвшөөрлийн холбогдох төлбөрийг төлөх, байгаль орчныг хамгаалах, холбогдох мэдээ тайлан гаргах үүрэг зэрэг (гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй) Ашигт малтмалын тухай хуулиар Тусгай зөвшөөрөлтэй холбогдуулан хүлээсэн бүх үүргээ биелүүлсээр ирсэн;
- 7.4 МУЗГ-ын ямар ч яам, агентлаг, аливаа аймаг, сумын удирдах дээд байгууллага, агентлаг, эсвэл аливаа бусад хувь хүн, хуулийн этгээдээс Худалдагчийн эсрэг, Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайд явуулсан ямарваа үйл ажиллагааны талаар ямарваа гомдлын шаардлага гаргаагүй бөгөөд Худалдагчийн мэдэж байгаагаар гаргахыг завдаагүй;
- 7.5 МУЗГ-ын ямар ч яам, агентлаг, аливаа аймаг, сумын удирдах дээд байгууллага, агентлаг, эсвэл аливаа бусад хувь хүн, хуулийн этгээдээс Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайд явуулсан ямарваа үйл ажиллагаатай холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй бөгөөд Худалдагчийн мэдэж байгаагаар тийм ажиллагаа эхлүүлэхийг завдаагүй;
- 7.6 Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайд, эсвэл түүнтэй холбогдуулан ямарваа үйл ажиллагаа явуулахыг хориглосон шүүхийн тогтоол, шийдвэр, эсвэл засгийн газрын аливаа яам, агентлагийн тушаал гараагүй;
- 7.7 Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайд явуулж буй үйл ажиллагаатай холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Худалдагчаас холбогдох байгууллагад гаргасан бүх тайлан мэдээний хуулбарыг Худалдан авагчид хүргүүлсэн; түүнчлэн
- 7.8 Худалдагчийн мэдэлд байгаа, Тусгай зөвшөөрөлд хамрагдах талбайд явуулж буй үйл ажиллагааны талаарх бүх мэдээ, баримтын хуулбарыг 3(г)-д заасны дагуу Худалдан авагчид хүргүүлсэн.
8. Худалдан авагч нь дараах мэдэгдэл, баталгааг үүгээр гаргаж байна:
- 8.1 тэрээр Монгол улсын хуулиудын дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компаниар зохих ёсоор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа;
- 8.2 өөрийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах бүх лиценз, зөвшөөрлийг авсан;
- 8.3 Тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу эзэмших эрхтэй; бөгөөд

8.4 энэхүү Гэрээг байгуулж, түүний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болно.

9. Энэхүү:

9.1 Гэрээг хуулиудын зөрчилдөөний хэм хэмжээг үл харгалзан Монгол улсын дотоодын хуулиар тайлбарлаж, зохицуулна;

9.2 Гэрээнд гагцхүү талуудын зохих ёсоор бичгээр үйлдсэн баримт бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно;


9.3 Гэрээний дагуу эдлэх эрхээ талууд тус тусын нэгдмэл сонирхолтой этгээдэд шилжүүлж болох (энэ тохиолдолд эрх шилжүүлэгч нь энэхүү Гэрээнд заасан нөхцлийн дагуу эрх шилжүүлэн авагчийн хамт үүрэг хүлээнэ)-ыг эс тооцвол алнваа тал нь энэхүү Гэрээг нөгөө талынхаа зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхгүй;

9.4 Гэрээ нь талууд, тэдгээрийн эрх залгамжлагчид, эрх шилжүүлэн авагчдын хувьд заавал биелүүлэх хуулийн хүчинтэй байна.



Дээр заасныг нотлон дор гарын үсэг зурав.

АСА Групп ХХК

Гарын үсэг:



Нэр: Бөхчулууны Наранбаатар
Албан тушаал: Гүйцэтгэх захирал



Нэр: Нурбаимог Эрдэнэбат
Албан тушаал: Гүйцэтгэх захирал



Шилжүүлэх/Буцаан хүлээлгэн өгөх талбайн тодорхойлолт

Шилжүүлэх/буцаан хүлээлгэн өгөх талбай:

1. Аймаг (хот) Дорноговь Сум (дүүрэг) Ховд Планшетын код К-49-25-Б, Г
 2.
 3.

Шилжүүлэх/буцаан хүлээлгэн өгөх талбай нь дараахь булангийн солбицлуудтай:

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг			Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	108	08	00	43	07	20	11						
2	108	10	00	43	07	20	12						
3	108	10	00	43	06	00	13						
4	108	12	10	43	06	00	14						
5	108	12	10	43	07	00	15						
6	108	13	30	43	07	00	16						
7	108	13	30	43	03	50	17						
8	108	19	10	43	03	50	18						
9	108	19	10	43	01	50	19						
10	108	08	0	43	01	50	20						


Үлдэж буй талбайн тодорхойлолт:

4. Аймаг (хот) Дорноговь Сум (дүүрэг) Ховд Планшетын код К-49-25-Б, Г
 5.
 6.

Үлдэж буй талбай нь дараахь булангийн солбицлуудтай:

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг			Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	108	08	0	43	07	20	11						
2	108	10	0	43	07	20	12						
3	108	10	0	43	06	00	13						
4	108	12	10	43	06	00	14						
5	108	12	10	43	07	00	15						
6	108	13	30	43	07	00	16						
7	108	13	30	43	03	50	17						
8	108	19	10	43	03	50	18						
9	108	19	10	43	01	50	19						
10	108	08	0	43	01	50	20						

Тамга



Тодорхойлолт гаргасан:

[Signature]

/Гарын үсэг/

[Signature]

/Нэр/



“Новаметалл ресурс” ХХК-д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР


15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26-36-28, Факс: 31-03-70
E-mail: info@mram.gov.mn

2010.05.21 № 6-4197
танай _____-ны № _____-т

**Шийдвэрийн дагуу мэдэгдэл
хүргүүлэх тухай**

“АСА групп” ХХК-ийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дахь Өндөр толгой нэртэй 9619.26 гектар талбай бүхий XV-008573 тоот тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг XV-008573-009-ТF дугаарт бүртгэн хянаж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтад заасныг үндэслэн ГУУКХ-ийн даргын 2010 оны 5 сарын 21 ны(ний) өдрийн 568 дугаар(дүгээр) шийдвэрээр ашигт малтмалын хайгуулын XV-008573 тоот тусгай зөвшөөрлийг (тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүд хэвээр) танай компанид шилжүүлснийг бүртгэж, тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглэгээ хийснийг мэдэгдье.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН
КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Л.ДАВААЦОГТ

AGREEMENT ON PURCHASING INFORMATION ON EXPLORATION ACTIVITIES AND ON THE TRANSFER OF SPECIAL LICENSE

This Agreement has been signed on April 21, 2010 between ASA Group LLC, established within the framework of Mongolian legislation, with the Register number of 2804255 and the State registration number of 9011039072 (further “the Seller”); and Novametal Resource LLC, established within the framework of Mongolian legislation, with the Register number of 5372658 and the State registration number of 9011232015 (further “the Buyer”).

GENERAL PROVISIONS

- A. The seller is the registered owner of the minerals exploration special license 8573X (further “the Special license”), which has been issued by the Geology and Mining Cadastre Division of the Mineral Resource Authority of Mongolia (further “the GMCD”), in accordance with the Minerals law of Mongolia (further “the Minerals law”). The area between the meeting point of the latest width and length is the property area of the special license of the Agreement, which is stated in the appendix of the special license.

- C. The seller has completed exploration activities in the property area of the special license, and submitted a report to related agencies of the Government in accordance with the Minerals law. The report, other documents and information relating to exploration activities shall be the information on the property area of the special license of the Agreement.

CONSENSUS

The Parties have reached the consensus in following matters:

1. The seller has agreed to trade this information on the property area of the special license to the buyer in accordance with provisions and prerequisites of the Agreement; and the buyer agreed to purchase this information from the seller.

2. The payment for a purchase of the information on property area of the special license (further “the Purchase price”) is 500.000 (Five hundred thousand) MNT.

3. The seller shall provide the buyer with the following documents on the day of signing the Agreement:
 - a) The certificate of the special license, appendixes and images (further “the documents of special license”);

 - b) The signed original copy of the agreement on the transfer of special license and documents necessary for a transfer of the special license to the buyer (further “the seller's documents for a transfer of the special license”);

- c) The certified copy of the State registration certificate of the seller;
 - d) The information on the property area of the special license.
4. The seller has agreed to pay applicable taxes arising from the trading of information on the property area of the special license to tax office, and provide with the statement on tax return.
 5. The seller is a) The sole lawful owner of information on the property area of the special license; b) As mentioned in provision (3): Upon transferring the information on property area of the special license to the buyer, the seller has guaranteed the lawful right to ownership of information on property area of the special license and its transfer free of third party's right to this information.
 6. The buyer shall submit documents on the special license and documents on the transfer of special license to the GMCD as soon as possible. Accordingly, the seller has agreed to complete and provide with all the related documents and contracts in order to proceed with the transfer of the special license to the buyer.
 7. The seller guarantees the following matters:
 - 7.1 The special license is free of third party's right to it;
 - 7.2 The seller has not made a contract with another entity in relation to the special license;
 - 7.3 The seller has been responsible in terms of obligations in compliance with the Minerals law on the payment of the special license, environmental protection, and the submission of necessary reports (and any other obligations not limited to it);
 - 7.4 There has been no complaint issued and/or intention to issue complaint in relation to activities at the property area of the special license by any ministries, agencies, aimag and soum authorities, or by individuals and legal entities;
 - 7.5 There has been no investigation and/or intention to investigate in relation to activities at the property area of the special license by any ministries, agencies, aimag and soum authorities, or by individuals and legal entities;
 - 7.6 There has been no issuance of court decree and/or ministerial or agencies' order in relation to the property area of the special license or prohibiting any activities in this area;
 - 7.7 The copies of reports in relation to activities in the property area of the special license have been provided to the buyer in accordance with the Minerals law;
 - 7.8 The copies of the all information and documents regarding the property area of the special license have been provided to the buyer in accordance with the provision 3(d).

8. The buyer guarantees the following matters:
 - 8.1 The buyer is engaged in activities through the limited liability company established in compliance with the legislation of Mongolia;
 - 8.2 The buyer acquired all licenses that are necessary to engage in activities;
 - 8.3 The buyer has the right to ownership of the special license in accordance with the Minerals law;
 - 8.4 The buyer has the right to establish this Agreement and be responsible for obligations arising from it.

9. This Agreement:
 - 9.1 The Agreement is interpreted by and subject to the national legislation of Mongolia, notwithstanding the norms of conflict of laws;
 - 9.2 The amendments to the Agreement shall be made solely through appropriate authorized documents of the parties;
 - 9.3 Both parties can transfer rights arising from the Agreement to their entities with common interest; and neither of the parties shall transfer this Agreement to other entities without mutual consensus;
 - 9.4 The Agreement has a legal force for implementation in relation to the parties, their successors of rights, and their successors of transferred rights.

ASA Group LLC

Signature: /Naranbaatar Bukhchuluun/, CEO

Novametal Resource LLC

Signature: /Erdenebat Chuvaamed/, CEO

(page 5)

Mineral Resource Authority
Geology and Mining Cadastre Division

Definition of the area to transfer/return

(The length and width of the area to transfer/return is shown in the table 1)

(The length and width of the area that is left is shown in the table 2)

Definition issued by

/Naranbaatar B./

(page 6)

To: Novametal Resource LLC

Mineral Resource Authority
The Implementing Agency of
the Government of Mongolia

2010/05/21

/About the note on the decision/

The transfer of special license XV-008573 of ASA Group LLC, covering 9619.26 hectares of area called Undur Tolgoi located in Khatanbulag soum of Dornogobi aimag, has been reviewed and registered under the number of XV-008573-009-TF. In compliance with the Minerals law provision 49 and clause 49.2, and based on the decision with number of 568 from May 21, 2010 issued by the director of GMCD, the special license XV-008573 on minerals exploration has been transferred to your company and registered in the appendix of the special licenses.

Director
tGeology and Mining Cadastre Division

/Davaatsogt L./